

БНСВУ-ын «Ши Тхат» хэвлэлийн газраас эрхлэн 1983 онд «Бүгд Найрамдах Монгол Ард Улс» хэмээх ном хэвлэн гаргажээ*. Энэ номыг Ханойн Их Сургуулийн түүхийн тэнхимийн орлогч эрхлэгч Нгуен Куок Хунг бичжээ. Дөрвөн үндсэн хэсэгтэй энэ ном Монголын байгаль, цагуур, хүн ам, ашигт малтмалын талаар товч өгүүлээд Монголын нутаг дэвсгэр дээр хүн оршин суусан үеэс эхлэн Монгол овог аймгууд төр улсаа байгуулан мандаж буурч явсан түүх, ардын хувьсгал хийх болсон шалтгаан, түүний түүхэн ялалт, ардын хувьсгалын дараахь ардчилсан болон социалист шатны гол үндсэн зорилтууд хэрхэн биелж ирсэнийг Вьетнамын уншигчдад нэн ойлгомжтой, цэгцтэй танилцуулжээ. Зохиогч номоо бичихдээ манай судлаачдын 70, 80-аад оны эхний зарим бүтээл, мөн МАХН-ын их хурлуудын баримт бичиг тоо бүртгэлийн албан ёсны мэдээнүүдийг ашигласан нь тодорхой байна.

Номын гол хэсэг Ардын хувьсгал ялсанаас хойшхи БНМАУ-ын нийгэм, эдийн засгийн асуудалд зориулагджээ.

1921 он Монгол оронд ардын хувьсгал ялж, империализм феодализмыг эсэргүүцсэн ардчилсан өөрчлөн байгуулалт хийх зорилтыг 40 өөд оны эхээр шийдвэрлэсэн билээ. Түүхийн энэ зурвас үеийн нийгэм эдийн засгийн өөрчлөлтийг «1921 оны ардын хувьсгал ба социалист хувьсгалд шилжих бэлтгэлийн үе (1921—1940)» гэсэн хэсэгт тусгажээ.

Улс орны өвөрмөц нөхцөл байдалд тохируулан ардчилсан шатны зорилтуудыг хэрхэн хэрэгжүүлсэн талаар бичихдээ Монголын хувьсгалын ардчилсан шатан дахь нийгэм-эдийн засаг, улс төр, соёл, үзэл суртлын өөрчлөн байгуулалт нь феодализм, империализм, капитализмын эсрэг агуулгатай социалист чиг хандлагатай байсныг өөрөөр хэлбэл манай намаас Монголын ард түмний хувьсгалт ардчилсан өөрчлөлтийг социалист хэтийн төлөвтэй холбон шийдвэрлэсэн түүхэн арга замыг зохиогч тодорхой харуулжээ. (22-55-р тал).

Номын дараахь хэсэгт 1940-өөд оноос 80-аад оныг хүртэлх манай социалист байгуулалтыг «Монгол орон социализмын замаар» гэсэн гарчигт тусган харуулжээ. Зохиогчийн авсан түүхэн энэ зурвас үед Монгол орон социализмын үндсийг байгуулж дуусгаад (40-өөд оны эхнээс 60-аад оны эхээр) улмаар социализмын бүрэн ялалтыг хангах янз үед орж социализмын материал-техникийн баазыг өргөн байгуулж эхэлсэн билээ.

Намаас нийгмийн амьдралыг социалист үндсэн дээр өөрчлөн байгуулах чухал зорилтыг хэрэгжүүлэхдээ юуны өмнө хувьсгалын ардчилсан шатны ололтонд бат тулгуурлажээ. Энэ үед БНМАУ-ын улс гөрийн систем улам боловсронгуй болж, социалист үйлдвэрлэлийн харилцаа бүрэн ялж, социалист байгуулалт гүнзгийрэв. Тэгэхдээ ардчилсан өөрчлөлт нь социалист өөрчлөлт болон шилжсэн диалектик нэгдлийг монгол дахь тухайн үеийн нийгмийн хөгжлийн баримтаар од харуулжээ. (64-67)

* “Nuoc Cong hoa nhan dan Mong co. Nha xuat ban "Su that”, Hanoi, 1983. 115 tr.

БНМАУ 1961 онд социалист орнуудын эдийн засгийн харилцан туслах зөвлөлд гишүүнээр элсэн орж, тус оронд социализм байгуулж дуусгах шинэ үеийн эдийн засгийн гол агуулга тухайлбал улс орныг цаашид үйлдвэржүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг механикжуулах, улс ардын аж ахуйн бүх салбарын техник хангамжийг дээшлүүлэх замаар социализмын материал-техникийн хамгийн ашигтай цогцолбор бүхий бааз байгуулах ажилд шургуу оржээ. Энэ үед БНМАУ-ын социалист нийгмийн үйлдвэрлэх хүчин эрчимтэй хөгжиж, эдийн засгийн хүч чадал улам бэхжиж, нийгмийн социалист харилцаа боловсронгуй болж, соёл шинжлэх ухааны салбарт үлэмж амжилт олсоныг тоо баримтаар харуулжээ.

БНМАУ-ын социалист байгуулалтын бололтод ах дүү социалист орнууд ялангуяа ЗХУ-тай тогтоосон найрамдал хамтын ажиллагаа чухал нөлөө үзүүлж байгааг зохиогч онцлон тэмдэглэжээ. (83—86-р Тiал)

Зохиолын төгсгөлийн хэсэгт БНМАУ-ын гадаад бодлогын үйл ажиллагааны талаар бичихдээ БНМАУ үүссэн цагаасаа эхлэн олон улсын аюулгүй байдал, улс түмний найрамдал, хамтын ажиллагаа, хөгжил дэвшлийн төлөө тууштай тэмцэж ирснийг бодит баримтаар дурдаад 1954 онд дипломат харилцаа тогтоосноос хойшхи БНСВУ, БНМАУ-ын интернационалч найрамдал олон талт хамтын ажиллагаа тасралтгүй өсөн бэхжиж байгааг дурджээ.

Уг ном БНМАУ-ын тухай нягт нямбай бичигдсэн дорвитой зохиол болжээ. Гагцхүү Монгол нутагт эртний хүн нутагшсан он цагийг 200 мянган жилийн тэртээгээс (17-р тал) гэсэн нь нэлээд хуучирсан ойлголт бөгөөд сүүлд хэвлэгдсэн БНМАУ-ын түүхийн нэгэн ботид 300 мянган жилийн өмнөөс гэж бичсэнийг баримтлах нь зүйтэй болов уу. (Дашрамд өгүүлэхэд Монгол нутгаас 1987 онд Зөвлөлт-Монголын ар хеологчдын илрүүлсэн зарим олдвор дээрх он цагийг дахин 200 мянган жилээр ч урагшлуулж магадгүй байгаа билээ).

Өгүүлэн буй зохиолд хувьсгалын өмнөх Монголын утга соёлын уламжлалыг өчүүхэн ч дурдаагүй нь харамсалтай боловч БНМАУ-ын орчин үеийн социалист байгуулалтын ололт амжилтыг бүхэлд нь Марксист байр сууринаас нэгтгэн Вьетнамын өргөн олон уншигчдад системтэй танилцуулсанаараа чухал бүтээл болжээ.

С. ДАШЦЭВЭЛ
Түүхийн ухааны дэд эрдэмтэн